

**СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨМЖ**

2024 оны 01 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/576 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ын дагуу Сүхбаатар аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг танилцуулж байна.

Үйл ажиллагааны үр дүнг 5 чиглэлийн хүрээнд 21 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн:

Улсын бүртгэлийн хэлтэс	
1.Нэгжийн чиг үүргийн үнэлгээ /50 оноо/	1.Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа /10 оноо/
	2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа /10 оноо/
	3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа /10 оноо/
	4.Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагаа /10 оноо/
	5.Архивын үйл ажиллагаа /10 оноо/
2.Төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилтийн үнэлгээ /15 оноо/	1.Хэлтсийн гүйцэтгэлийн тайлан /10 оноо/
	2.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгөгдсөн үүрэг, даалгавар, тушаалын хэрэгжилт /5 оноо/
3.Санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээ /10 оноо/	1.Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулсан байдал /0.5 оноо/
	2.Үйлчилгээний орлого төвлөрүүлэлт /0.5 оноо/
	3.Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт хуульд заасан хугацаанд, үнэт цаас, маягтын тайлан хүргүүлсэн байдал /1.5 оноо/
	4.Үнэт цаас, маягт, бичиг хэрэг, хангамжийн материалыг үр ашигтай, хэмнэлттэй, захиран зарцуулж, өмч хөрөнгийн тооллого хийсэн эсэх. /0.5 оноо/
	5.Аудитын дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /2 оноо/
	6.Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал /5 оноо/
4.Нэгжийн нээлттэй байдлын үнэлгээ /8 оноо/	1.Нэгжийн ил тод нээлттэй байдлын үнэлгээ /6 оноо/
	2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ /2 оноо/
5.Бусад чиглэлээр өгсөн үнэлгээ /17 оноо/	1.Идэвх санаачлага, шинэлэг ажил /5 оноо/
	2.Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт /2 оноо/
	3.Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт /2 оноо/
	4. Хуулийн хэрэгжилт, ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээ /4

оноо/
5.Сургалт, семинар зохион байгуулсан болон хамрагдсан байдал /2 оноо/
6.Тайлан мэдээг үнэн зөв, гүйцэт ирүүлсэн, хүргүүлсэн байдал, үйл ажиллагаа тайлагнасан байдал, ажлын уялдаа холбоо /2 оноо/
<b>ЕРӨНХИЙ ОНОО /Нийт онооны дээд хэмжээ 100 байна./</b>

<b>Нэг. Нэгжийн чиг үүргийн үнэлгээ</b>						
№	Чиг үүрэг	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо	Үнэлгээ	Дундаж үнэлгээ	Үнэлгээ өгсөн
1.1	Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаа /10 оноо/	Чиглэл зөвлөмжийн биелэлт	2	2	8	ИУБГ
		Бүртгэлийн алдаа, зөрчил	3	2		
		Шинэлэг ажил	1	1		
		Идэвх санаачлага	2	1		
		Сургалтад оролцсон байдал	1	1		
		Тайлан мэдээ, илтгэх хуудас ирүүлсэн байдал	1	0		
1.2	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа /10 оноо/	Хууль тогтоомжийн хэрэгжилт	2	1	8	ХЭУБГ
		Үүрэг, чиглэлийн биелэлт	2	2		
		Тайлан, мэдээ хугацаандаа ирүүлсэн	1	1		
		Тайлан, мэдээ үнэн зөв ирүүлсэн	2	2		
		Идэвх, санаачлага	1	1		
		Цахим бүртгэл хөтөлсөн	1	1		
1.3	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа /10 оноо/	Цахим мэдээллийн үнэн зөв байдал	20	13	7	ЭХЭУБГ
		Үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилт, хугацаандаа ирүүлсэн эсэх	20	17		

		Үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдээс гаргасан гомдол, санал шийдвэрлэсэн байдал	10	8		
		Захиалгаар барьсан орон сууцны жагсаалт цахимжуулалт	20	10		
		Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, арилгасан байдал	20	15		
		Сумдад эрхийн улсын бүртгэл хөтөлсөн байдал	10	7		
1.4	Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагаа /10 оноо/	Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааг 10 шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн байдал	10	8	8	ХШГ
1.5	Архивын үйл ажиллагаа /10 оноо/	Архивын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан	2	2	10	УБНА
		Архивын талаарх шинэлэг ажил	2	2		
		Мэдээ ирүүлэлт	3	3		
		Иргэнийн улсын бүртгэлийн маягтын галиг, цахимжуулалт, хугацаандаа ирүүлсэн эсэх	2	2		
		БНШАЗК-ын үйл ажиллагаа	1	1		
Нийт авбал зохих 50 онооноос 41 оноо						

Тайлбар:

Хэлтсийн хяналт шалгалтын үнэлгээ нь хяналтын байцаагч болон хэлтсийн дарга нарт өгсөн оноо юм.

1. Н.Бадрахцог авбал зохих 10 онооноос 8 оноо авсан.

### Хоёр. Төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилтийн үнэлгээ

#### 2.1.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 84.63 хувь буюу авбал зохих 10 онооноос 8 оноо авсан.

Арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь								Дундаж
	/-/	0	50	60	70	80	95	100	хувь
27	-	1	1	-	6	4	1	14	84.63

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

№	Арга хэмжээ	%	Тайлбар
3.6	Зөрчлийн тухай хууль тогтоомжийн дагуу Зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил арилгах, Торгууль шийтгэвэрийг хуулийн дагуу оногдуулах, зөрчлийн тоог бууруулах.	50	Эрчимжүүлэх шаардлагатай. Тайлагналт хангалтгүй шалгуур үзүүлэлтийн дагуу тоо баримттай тайлагнах
4.3	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчий ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих	0	2.4 дэх арга хэмжээтэй давхардсан тул шалгуур үзүүлэлтээс хасаж тооцов.

#### 2.2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт

УБЕГ-ын даргаас 2023 онд нийт 48 үүрэг даалгавар, чиглэл өгөгдсөнөөс хэрэгжилт 52.8% хувь буюу авбал зохих 5 онооноос 2.6 оноо авсан.

### Гурав. Санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээ

№	Үйл ажиллагаа	Авбал зохих оноо	Үнэлгээ	Үнэлгээ өгсөн
3.1	Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулсан байдал /0.5 оноо/	0.5	0.49	СААХ
3.2	Үйлчилгээний орлого төвлөрүүлэлт /0,5 оноо/	0.5	0.5	СААХ
3.3	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт хуульд заасан хугацаанд, үнэт цаас, маягтын тайлан хүргүүлсэн байдал /1.5 оноо/	1.5	1.5	СААХ
3.4	Үнэт цаас, маягт, бичиг хэрэг, хангамжийн материалыг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулалт, өмч хөрөнгийн тооллого хийсэн эсэх /0.5 оноо/	0.5	0.49	СААХ
3.5	Аудитын дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /2 оноо/	2	1	БТДШГ

3.6	Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал /5 оноо/	5	5	БТДШГ
Нийт авбал зохих 10 онооноос		8.98 оноо		

Тайлбар:

-Санхүүгийн тайлангийн аудитын 3 зөвлөмж авсан.

### Дөрөв. Нэгжийн ил тод байдлын үнэлгээ

#### 4.1.Нэгжийн ил тод байдлын үнэлгээ

2023 оны ил тод байдлын үйл ажиллагаанд 23 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийхэд авбал зохих 6 онооноос 6 оноог авсан

#### 4.2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2023 онд 153 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаандаа 153 байршуулсан. Авбал зохих 2 онооноос 2 оноог авсан.

### Тав. Бусад чиглэлээр өгсөн үнэлгээ

№	Үйл ажиллагаа	Авбал зохих оноо	Үнэлгээ	Үнэлгээ өгсөн
5.1	Идэвх санаачлага, шинэлэг ажил /5 оноо/	5	3	БТДШГ
5.2	Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт/2 оноо/	2	2	ТГ
5.3	Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт /2 оноо/	2	2	БТДШГ
5.4	Хуулийн хэрэгжилт, ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээ /4 оноо/	4	3.5	ТГ
5.5	Сургалт, семинар зохион байгуулсан болон хамрагдсан байдал /2 оноо/	2	1.6	ХАСХ
5.6	Тайлан мэдээг үнэн зөв, гүйцэт ирүүлсэн, хүргүүлсэн байдал, үйл ажиллагаа тайлагнасан байдал, ажлын уялдаа холбоо /2 оноо/	2	0,8	ТГ
Нийт авбал зохих 17 онооноос		12.9 оноо		


Тайлбар:

- Шинэлэг ажлын ач холбогдол цар хүрээг харгалзан үнэлгээ өгсөн;

### Зургаа. Санал, зөвлөмж, цаашид анхаарах асуудлууд

Хэлтсийн үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээ “81.48” буюу “тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээгээр дүгнэгдсэн.

Үйл ажиллагааны үр дүнг өмнөх онуудын үр дүнтэй харьцуулан харуулбал:



Хэлтсийн 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ өмнөх оноос 2.74 функтээр буурсан үзүүлэлттэй байна.

Цаашид дараах асуудалд анхаарч, үйл ажиллагааг сайжруулахыг зөвлөж байна. Үүнд:

1. Гүйцэтгэлийн тайланг ЗГХЭГ-ын даргын 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу тайлагнахдаа нийтлэг болон тусгай шаардлагыг хангаж иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, тодорхой, товч байх гэсэн нийтлэг шаардлагыг баримтлахын зэрэгцээ тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг тодорхой дурдах нь хамгийн чухал юм; Гүйцэтгэлийн тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцна./
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ирүүлэхдээ:

Хэдэн зорилт, арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрсэн байна, хэд нь хүрээгүй байна, шалтгаан, нөхцөл нь ямар байсан эсэх;

Төлөвлөлтийн шатанд алдаа гарсан уу, тэр нь хэрэгжилттэй холбоотой юу, санхүүжилтийн асуудал байсан эсэх;

Удирдлага, зохион байгуулалт хангалттай сайн байж чадсан, гүйцэтгэл нь үр дүнтэй байсан эсэх;

Тайланг шалгуур үзүүлэлтийн дагуу оновчтой , зөв тодорхойлж тайлагнаж байгаа эсэхэд хэлтсийн дарга хяналт тавьж баталгаажуулж байх;

Тайлагналыг шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн ажлаа бүрэн, оновчтой тайлагнах;

3. УБЕГ-ын даргаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг заасан хугацаанд ирүүлж, чиглэлийн хэрэгжилтийг ханган, хяналт тавин ажиллах;
4. Аудитын зөвлөмжгүй ажиллах;
5. Тамгын газарт хэлтсийн тайлан мэдээг үнэн зөв, гүйцэт, оновчтой тайлагнаж, заасан хугацаанд ирүүлж уялдаа холбоотой ажиллахад анхаарах;
6. Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
7. ЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон төрийн алба хаагчийн үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэн хяналт тавьж ажиллах;
8. Байгууллагаас зохион байгуулагдаж буй сургалт, семинарт алба хаагч нар идэвх санаачлагатай бүрэн хамрагдах;
9. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг мөрдлөг болгох;

Шалгуур үзүүлэлтийг жилдээ хэрэгжих боломжтой, тоон болон чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, зорилтот түвшний тусгал байхаар тодорхойлох;

Суурь түвшинг зорилт, арга хэмжээ эхлэх үеийн, эсвэл эхлэхээс дөнгөж өмнөх үеийн байдлын талаарх тоон болон чанарын мэдээллийг агуулсан байдлаар тодорхойлох;

Зорилтот түвшинг хүрэх буюу хийх гэж буй зүйлийн тоо, хугацаа, байрлал зэргээр илэрхийлж, байгууллагын тухайн цаг хугацаанд хүрэхийг хүсч буй шалгуур үзүүлэлтийн өссөн тоогоор илэрхийлэгдсэн түвшин байхаар тодорхойлох;

10. Энэхүү зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 03 сарын 20-ны өдрийн дотор Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газарт ирүүлэх зэрэг болно.

**БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**